



УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 04 сарын 15 өдөр

Дугаар 2223

Улаанбаатар хот

Г.Эрдэнэбатад сахилгын шийтгэл
ногдуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.5 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 27 дугаар зүйлийн 27.4.3 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсэг, 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.12 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1.2, 48.4 дэх хэсэг, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 16.3 дахь хэсэг, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.7 дахь заалт, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2023 оны А/1716 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 10.4, 10.6 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Иргэний улсын бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч Гочоогийн Эрдэнэбат төрийн албан хаагчийн нийтлэг үүргийг зөрчсөн нь Улсын бүртгэлийн ерөнхий газрын ёс зүйн дэд хорооны 2024 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн 03 дугаартай хурлын дүгнэлт, өөрийн гаргасан тайлбараар тогтоогдсон тул түүнд 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн нийт ажилтанд зарлах хэлбэрээр нээлттэй сануулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2. Өдөр тутмын үйл ажиллагаандаа холбогдох хууль тогтоомжийг мөрдөж, төрийн үйлчилгээг соёлтой хүргэхийг Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Иргэний улсын бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч Г.Эрдэнэбатад үүрэг болгосугай.

3. Албан хаагчдад ажлын хариуцлага, дэг журмыг чанд сахин ажиллахыг анхааруулж, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс /Б.Төгс-Эрдэнэ/-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар /Г.Цолмон/-т үүрэг болгосугай.

4. Энэ тушаалыг эс зөвшөөрвөл тушаалыг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор төрийн албаны төв байгууллагад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

ДАРГА



Д.ДЭЛГЭРСАЙХАН

142401138